



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлд:

XXXII.2.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлангийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны жилийн эцсийн байдлаар 6614 хуулийн этгээдийн нийт 91,798.5 тэрбум төгрөгийн хөрөнгө тоологдож байсан.

Дээрх ажлын хүрээнд хийгдсэн тооллогын програмыг өргөтгөж тайлан хүлээн авах цахим систем болгон өөрчилж, төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс хариуцан төрийн өмчийн, нийслэлийн өмчийн харилцааны газар, 21 аймгийн орон нутгийн өмчийн газрын ажилтан алба хаагчид хариуцан орон нутгийн өмчийн жилийн эцсийн санхүүгийн болон эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, статистик мэдээ, судалгааг хүлээн авч дүнг мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулж, хянах, нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Төрийн болон орон нутгийн өмчийн 6983 нэгж байгууллагын 96,328.7 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө байгаагаас 13,629.2 тэрбум төгрөгийн хөрөнгө орон нутгийн өмчид, 82,699.5 тэрбум төгрөгийн хөрөнгө төрийн өмчид бүртгэлтэй байна.


Дээрх төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө бүтцийн хувьд 33,203.4 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 63,125.3 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө байна.

Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нэгдсэн тайлангаар 2022 онд бүртгэлийн үнээр 13,632.7 тэрбум төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 10,351.3 тэрбум төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, статистик мэдээ судалгааг дээрх цахим системийг ашиглан хийж гүйцэтгэх, цаашид “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем”-ийг бий болгох ажлыг 2024 онд эхлүүлж 2025 онд багтаан дуусгах, Сангийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Автотээврийн үндэсний төв зэрэг төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



- 132320187
32-r_huraldaan.docx